



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№58 /502/

2023.04.10

Цаг үе, үйл явдал

АЖЛЫН ХЭСЭГ ХУРАЛДЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудын чуулган"-ыг зохион байгуулах ажлын хэсгийн анхны хурал боллоо.

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан тус ажлын хэсэг эл хуралдаанаараа "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын чуулган"-ыг угтан зохион байгуулах арга хэмжээний



төлөвлөгөө, "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын шилдэг офицер шалгаруулах уралдаан" хэрхэн зохион байгуулах зэрэг асуудлыг хэлэлцэж санал солилцон, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойллоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-4	-16

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	29

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,497	3,505
EUR	3,815	3,830
CNY	511	514
RUB	42.50	43.50
JPY	26.60	27
KRW	2.68	2.71

ЗУРХАЙ



2023.04.10 /ДАВАА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 19

**ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН
ТУУЛАЙ САР
ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ
ШАР НОХОЙ ӨДӨР**

Үс засуулбал:
Сайн нөхөртэй нөхөрлөнө
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.13-19.34
Барилдлага:
Өтлөх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Үхэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олддох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.

ЕРӨНХИЙ ЦЭРГИЙН БАГ АВАРГАЛЛАА



ЗХЖШ-ын Ахмадын хороо, "Ерөнхий цэрэг ассоциаци" ТББ-ын нэрэмжит Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн "Алдар" спорт хорооны спортын их танхимд явагдлаа.

Тэмцээнд Ерөнхий цэрэг, Холбоо, Цэргийн биеийн тамир, Улс төр, Ар тал, Артиллери, Танкны төрөл мэргэжлийн цэргийн холбоодын 55-аас дээш насны баг тамирчид оролцож өрсөлдөв.

7 баг сугалаагаар хоёр хэсэгт хуваагдаж тоглосноос "А" хэсгээс Ерөнхий цэргийн баг Улс төр, Холбоо, Артиллерийн багийг хожиж 1 дүгээр байраар, удаад нь Холбооны баг онооны илүүгээр 2 дугаар байраар шалгарлаа.

"Б" хэсэгт орсон 3 багаас Ар талын баг Танк, Цэргийн биеийн тамирын багуудыг хожиж 1 дүгээр байраар, Цэргийн биеийн тамирынхан Танкны багийн хожиж 2 дугаар байраар хагас шигшээ

шатанд шалгарав.

Хагас шигшээд Ерөнхий цэргийн баг Цэргийн биеийн тамирын багийг 35:20-ын харьцаатай хожив. Ар талын баг Холбоочдыг хожлоо. Хүрэл медалийн төлөө Цэргийн биеийн тамир, Холбооны багууд өрсөлдөж 19:18-ын харьцаагаар буюу биеийн тамирчид хагас онооны илүүгээр холбоочдыг буулгаж авсан.

Алтан медалийн төлөө Ерөнхий цэргийн баг Ар талынхны эсрэг хөнгөн тоглож 24:13-ийн харьцаагаар хожив. Тэмцээний шилдэг тоглогчоор Ерөнхий цэргийн багийн түлхүүр тоглогч Л.Батболд шалгарч шагнал хүртлээ.

"Ерөнхий цэрэг ассоциаци" ТББ-ын тэргүүн бэлтгэл хурандаа Л.Ганбаатар дараа жилийн энэ уламжлалт тэмцээнийг Цэргийн биеийн тамирын холбоо зохион байгуулна гэж мэдэгдэв.

"УЛААН ОДХОН" СОНИН

ОРОН НУТАГТ "ОЮУТАН ЦЭРЭГ"-ИЙН ЕРӨНХИЙ БЭЛТГЭЛ ШАТНЫ СУРГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Монгол улсын Цэргийн албаны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Увс аймаг "Оюутан цэрэг" цэргийн ерөнхий бэлтгэл шатны сургалтыг зургаа дахь жилдээ зохион байгуулж байна.

Энэ жилийн сургалтад тус аймгийн Хөдөлмөрийн дээд сургуулийн 2, Улаангом Политехникийн коллежийн 7 нийт 9 оюутан хамрагдаж байна. Сургалт өнөөдрөөс Улаангом Политехникийн коллежийн цэргийн эрдмийн "Соёмбо" танхимд хичээллэж эхэлсэн бөгөөд оюутнууд 6-р сарын 1 ныг хүртэл анхан шатны сургалтад хамрагдах юм.

УВС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 684,971,418

Эдгэрсэн

Нийт: 657,778,752

Нас барсан

Нийт: 6,837,727

Цахим шууданд

ХИМИЧИН ОФИЦЕР, ТАМИРЧИН АХЛАГЧ ХОЁРЫГ ОНЦЛОХУЙД ...



мэдрэмж, хурд хүч гээд олон зүйлийг шаарддаг онцгой мэргэжил гэж тодотгож байсан юм.

Харин Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн жолооч, ахлагч Болдын Суваргахайрхан нь мөн л Архангай аймгийнх. Айлын ууган хүү, нэг дүүтэй. Дүү нь ч цэргийн бүсгүй юм байна. “Суваргахайрхан гэж нэрлэсний учир. Нутгийн хайрхны нэр үү” гэж асуухад “Миний аав ээж хоёр хүүгээ тогтоохын тулд лус савдгийн нэр хайрлаж, үрээ хамгаалсан юм гэнэ лээ. Миний охин дүүг мөн л Цагаансүм гэдэг. Хүний амьдрал таашгүй бөгөөд үр хүүхдээ элэг бүтэн авч үлдэх гэж их хайрхны нэр өгчдээ гэж одоо боддог юм. Би нэрэндээ дуртай” гэлээ.

Тэрээр 2008-2014 онд Монгол Улсын Их сургуульд улс төр судлаач, нийгмийн ухааны багш мэргэжлээр суралцаж, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид 2015 оноос хойш алба хааж байгаа ажээ.

Түүний илтгэх нэг чанар нь тэр хөнгөн атлетийн тамирчин. Олон улсын хэмжээний мастер цолтой. Бүс нутаг, улс орны тэмцээн уралдаанд олон жил тэргүүн эгнээнд нь гүйхийн зэрэгцээ 2011, 2012 онуудад БНХАУ-д

Нэр. Хүмүүний заяаг олж төрөхөд дагаж ирээд хорвоогоос буцахад дуурсагдаж үлддэг билээ. Монгол Улсад 40 гаруй мянган нэр бүртгэлтэй байдгаас өвөрмөц содон нэр нь 1000 гаруй гэнэ. Энэ олон мянган нэрийг дагаад онцгой содонг нь цуглуулж, тэмдэглэдэг өвөрмөц хоббитой хүмүүс ч байдаг санж.

Нийгмийн даатгалын байгууллагад насаараа ажилласан Н.Хүрэлбаатар гэдэг хүний цуглуулснаар “Бөөр, Хамар, Алагнүдэн, Магнайдүүрэн, Зүрх” гэж эрхтний нэрнээс эхлээд өгүүлбэрийн шинжтэй “Хэнмэдэхэв, Отгонбиз, Дуудагуул, Хүнд-Өргүүл”, гараг эрхэсийн “Од, Гариг, Нар, Сар” тэр бүү хэл гэр бүлээрээ “Цагаанхүү Ягаанхүү, Ухна Ямаа” зэрэг хувь тохиолоор таарсан хосууд хүртэл байдаг юм байна. Зэвсэгт хүчинд та бидний дунд ч мөн онцгой содон нэртэй алба хаагчид ч цөөнгүй байдаг бөгөөд Монгол Улсад цор ганц бүртгэлтэй нэрний эзэн ахмад Б.Барьмэд, ахлагч Б.Суваргахайрхан нарыг энэ удаа “Бидний нэг” буландаа онцолж байна. “Дуудах нэрийг эцэг эх өгч, дуурсах алдрыг өөрөө олдог” гэдэгчлэн тэдний бүтээж яваа түүхээр нь аялъя.

Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн цэргийн албаны офицер, ахмад Баттулгын Барьмэд нь Архангай аймгийн Өндөр-Улаан сумынх, эхээс дөрвүүлээ айлын

том. Ууган хүүгээ мэндлэхэд аав нь Архангай нутагтаа алдартай лам Лувсаныг гэртээ урьж, нуган үрд нь нэр хайрлахыг хүсэхэд “Барьмэд” хэмээн чихэнд нь шивнэжээ. Барьмэд нь Төвөд үг бөгөөд ямар нэгэн утга илэрхийлдэггүйг нэрний эзэн өгүүлж байв. Хүмүүст өөрийгөө танилцуулахаар “Казах нэр юм уу” гэж асуудаг. Би энгийнээр ойлгуулахын тулд “Барь, Мэд” гэж салгаж хэлдэг, найзууд, онжавууд, хамаатан ахан дүүс “Баарий” гэж дууддаг гэлээ.

Ахмад Б.Барьмэд нь 2007-2008 онд ҮБХИС-ийн Ахлагчийн сургуулийг дүүргэж, ажлын гараагаа Зэвсэгт хүчний 119 дүгээр ангиас эхлүүлсэн залуу. Химичин дайчдын нэг болж 2008-2011 он хүртэл алба хааж, улмаар 2011-2017 онд ОХУ-д Цацраг, хими, биологис хамгаалах цэргийн академид суралцжээ. Төгсөж ирээд салааны захирагч, техникийн офицер, ротын захирагч, саяхнаас цэргийн албаны офицераар дэвшин ажиллаж байгаа юм байна. Түүний гэргий Л.Баасанхүү Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид энгийнээр ажилладаг, тэд Билгүүн гэдэг нэг хүүтэй.


Ахмад Б.Барьмэдийн цаашдын зорилго урьд нь суралцсан ОХУ-ын цэргийн академидаа магистрын зэрэг хамгаалах гэнэ. Химичин дайчин болсноороо үргэлж бахархдаг, ажлын туршлага, мэдлэг чадвараас гадна сонор сэрэмж,



зохион байгуулагдсан 21 км марафон гүйлтийн хошой хүрэл медальт эр. Хичээл зүтгэлээрээ Зэвсэгт хүчний шилдэг тамирчдын нэг болж чадсан тэр бээр яг энэ цаг үед ч гэсэн “Улаанбаатар марафон” тэмцээнд оролцохоор бэлтгэлдээ гарснаа дуулгаж байсан юм.

Ахмад Д.БОЛОР

900 ГАРУЙ БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНИЙГ СУРГАЛТАД ХАМРУУЛАВ



Дайчилгааны тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх, дайчилгаатай хээрийн сургууль, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургуулийн бэлтгэл ажлыг хангуулах, томилгоот бүрэлдэхүүний тодотгол хийж тэдний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх онолын мэдлэг олгох зорилгоор Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб,

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн Дайчилгаа, хүний нөөцийн

тасагтай хамтарсан сургалтыг Алтанбулаг, Архуст, Баян, Баяндэлгэр, Баянцагаан, Баян-Өнжүүл Зуунмод, Эрдэнэ сумдад зохион явууллаа.

Сургалтад 900 гаруй бэлтгэл үүрэгтэн хамрагдлаа. Уг сургалтад хамрагдсан томилгоот нэгжүүд 2023 оны 8 сард зохион явагдах дайчилгаатай хээрийн сургалтад хамрагдах юм.

ТӨВ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

УУЛЧИН ДАЙЧИД СЭТГЭЛ ЗҮЙН СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон “Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг” Зэвсэгт хүчний 331 дүгээр ангид ажиллаж бүлгийн болон ганцаарчилсан уулзалтуудыг зохион байгууллаа.

Сургалтаар “Хамт олны сэтгэл зүй”, “Харилцааны сэтгэл зүй”, “EQ”,

“Цаг ашиглалт” сэдвээр мэдээлэл өгсний зэрэгцээ сэтгэл зүйн сорил, асуумжийг цэргийн алба хаагчдаас авч, тухайн хүний давуу болон сул тал, чадвар чадамжийг нь илрүүлж, цаашид өөрийгөө хэрхэн хөгжүүлэх талаар зөвлөгөө өгсөн юм.

Дэслэгч Б.МЯГМАРЖАВ

САЙН ҮЙЛС БҮХЭН ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ



Зэвсэгт хүчний 314 дүгээр ангийн “Ахлагчийн зөвлөл”-өөс ахлагчдын нийгмийн хамгаалал, ар гэрийг дэмжих зорилготой сайн үйлсийн аяныг өрнүүлээ.

Аяны хүрээнд ангийн гал сөнөөгч дэд ахлагч Б.Отгонжаргал байр түрээслэн амьдарч байсныг ажилд нь ойртуулж, саадгүй ажилдаа ирж очих нөхцөлийг бүрдүүлэн, гэрийг нь Төв аймгийн Эрдэнэ

сумаас Сэргэлэн сумын 1 дүгээр багт байршууллаа.

Мөн Төв аймгийн Сэргэлэн сумын 1 дүгээр баг, Баян зөрлөгт байрлах “Тэс Петролиум”-ын удирдлагад хүсэлт гарган эхнэр Б.Мөнгөнсувдыг тус компанид ээлжийн түгээгчээр ажиллуулахаар болсны зэрэгцээ 2 хүүхдийг нь тус багийн “Алтан түлхүүр” цэцэрлэгт хамруулахаар шийдвэрлэсэн юм.

ХААНЫ ЭРЭЛД ОЛОН УЛСЫН СУРГУУЛИЙН СУРГАГЧ БАГШИЙН /Т-3/-ЫН ДАМЖАА ЯВАГДАЖ БАЙНА



Хааны эрэлд-23 олон улсын энхийг дэмжих ажиллагааны “Сургагч багш”-ын дамжаа Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвд энэ сарын 4-нөөс 14-ний өдрийн хооронд явагдаж байна.

Энэ жилийн дамжааг АНУ-ын Энхийг дэмжих хөтөлбөр “GPOI”-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Зэвсэгт хүчин бие даан явуулж байгаагаараа онцлог байна.

Тус дамжаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний 4, “Дэлхийн

энхийг санаачлах хөтөлбөр”-ийн 2 чиглүүлэгч багш хичээл зааж байгаа бол суралцагчаар Монгол Улсын Зэвсэгт хүчний анги, байгууллагаас 24, Балба, Филиппин, АНУ, Индонез, Япон зэрэг орноос 13 офицер, ахлагч суралцаж байна.

Түүнчлэн эмэгтэй цэргийн алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд тус дамжаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний 1 эмэгтэй сургагч багш, 5 эмэгтэй цэргийн алба хаагч, Япон улсын өөрийгөө хамгаалах хүчнээс 1

эмэгтэй цэргийн алба хаагч оролцож байгаа юм.

Дамжаа нь тактикийн түвшинд онолын мэдлэг олгож дадлагаар баталгаажуулан 2 үе шаттай явагдах ба сүүлийн шатанд оролцогч нар НҮБ-ийн стандарт 6 цэгүүдийн хичээлийн хөтөлбөр төлөвлөгөө, дадлагын цагийн байдлыг боловсруулан “Хааны эрэлд” олон улсын хамтарсан сургуульд оролцох салаадад ЭСА-ны мэдлэг чадвар олгоход оршино.

Монгол улс, тэр дундаа Зэвсэгт хүчнийг гадаадын улс орнуудад сурталчлах, дадлага туршлага хуримтлуулах өндөр ач холбогдолтой уг дамжааг эх орондоо уламжлал болгон зохион байгуулж НҮБ-ын бусад сургалтыг явуулах зөвшөөрөл буюу НҮБ-ын батламж авахаар зорин ажиллаж байгаа талаар холбогдох албаны хүмүүс онцолсон юм.

